



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 05 сарын 09 өдөр

Дугаар А/104

Мандалговь

"Саммит компьютер технологи"
ХХК-тай гэрээ байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих "Их соёл-Эх үндэс төсөл хөтөлбөр багц-1 /Дундговь, Говьсүмбэр/" -ын гүйцэтгэгчээр шалгарсан "Саммит компьютер технологи" ХХК-тай 798,368,420 (долоон зуун ерэн найман сая гурван зуун жаран найман мянга дөрвөн зуун хорь) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

2. Батлагдсан техникийн үзүүлэлтийн дагуу ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг "Саммит компьютер технологи" ХХК-ний захирал (Ш.Энхболд)-д үүрэг болгосугай.

3. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван) нарт үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Л.ДОРЖБАТ

4822150231